



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/75

Мөрөн сум

Барилгын ажлыг хүлээж авах
комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.1, 48.6, Засгийн газрын 2020 оны 246, 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн хувиарлах байгууламжийн барилгын дээврийн засварын ажлыг хүлээж авах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Б.Энхжаргал (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын
Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

П.Даваа-Очир (Мэргэжлийн хяналтын газрын Өргөх байгууламжийн
хяналтын улсын байцаагч)

Х.Даваасүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө
оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн,
Ерөнхий архитектор)

Ж.Жавзанпагма (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн
хэлтсийн Архивын тасгийн дарга)

Ж.Нацагдорж (Онцгой байдлын газрын Гал түймрийн хяналтын
улсын байцаагч, хошууч)

Э.Сумъяасүрэн ("Хөвсгөл барилга захиалагчийн төв"
ОНӨААТҮГазрын хяналтын инженер)

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:

М.Мөнхдэлгэр ("Сүрэн гүүд проект" ХХК-ийн Захирал)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

Б.Чулуунсүрэн ("Хөх гүрэн констракшн" ХХК-ийн Захирал)

Д.Түмэнцогт ("Хөх гүрэн констракшн" ХХК-ийн талбайн даамал)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:

Л.Насанжаргал (Нэгдсэн эмнэлгийн Санхүү эдийн засгийн аж ахуйн
албаны дарга)

Н.Амарбаясгалан (Нэгдсэн эмнэлгийн Инженер техник эрсдэл
аюулгүй байдал хариуцсан менежер)
Б.Бүдрагчаа (Нэгдсэн эмнэлгийн Инженер техникийн албаны дарга)
Г.Баярмаа (Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаа хариуцсан захирал)

Комиссын нарийн бичгийн дарга:

Б.Баасанжав (Хөвсгөл аймгийн Газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газрын мэргэжилтэн)

2. Барилгын ажлыг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомж, Барилга, хот байгуулалтын яамны сайдын зөвлөмж, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын зөвлөмж, коронавируст халдвар (ковид-19)-аас урьдчилан сэргийлж, халдвар хамгааллын дэглэмийг баримтлан зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2022 оны 6 дугаар сарын 31-ний өдрийн дотор танилцуулахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Барилгын ажлыг хүлээж авахтай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Б.Баасанжав)-д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга, байгууламжийн ажил хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН